



**ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУСААР ЭКСПОРТЛОГДСОН
СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ ЮНИДРУА /ХУВИЙН ЭРХ ЗҮЙН
НЭГТГЭХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН/-ИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага, үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.” гэж, мөн 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 25.1-д “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх,” гэж, 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.5.9-д “Хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана” гэж, 7.3.6-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна” гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) соёлын биет өвийг хууль бус арга замаар хилийн чанадад гаргаж худалдах нь улс орны соёлын биет өвийн үнэ цэнтэй байдлыг дордуулан, ядууралд оруулахаас гадна улс хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлдгийг сануулж, соёлын биет өвийн хууль бус худалдаатай тэмцэхэд хамтын хүчин

чармайлт гарган ажиллахыг оролцогч талуудад зөвлөсөөр ирсэн. Энэ хүрээнд ЮНЕСКО-ийн 1970 оны Соёлын эд зүйлийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц болон 1995 оны "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцын механизмыг хослуулан ашиглаж, соёлын биет өвийг хууль бус эргэлттэй тэмцэхийг уриалж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйн нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенц"-ыг соёрхон батлахаар тусгасан.

Монгол Улс 2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг шинэчилж, өнөөдрийг хүртэлх хугацаанд салбар дундын 56 хуульд холбогдох зохицуулалтыг тусгаж, 27 дүрэм журмыг батлан хэрэгжүүлснээр соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт сайжирч, иргэдийн мэдлэг, ойлголт дээшлэх зэргээр соёлын биет өвийн эх төрх, бүрэн бүрэн байдлыг хамгаалахад мэдэгдэхүйц эерэг үр дүн гарч байгаа ч соёлын биет өвийг хулгайлах, хууль бусаар худалдах явдал буурахгүй байна. Сүүлийн 5 жил /2017-2021 он/-д хулгайлах гэмт хэргийн улмаас 52 түүх, соёлын дурсгалт зүйл алга болсны 22 дурсгалт зүйлийг эрэн сурвалжилж олсон бол бусад 30 ширхэг дурсгалт зүйлийг өнөөг хүртэл олдоогүй байна.

Соёлын биет өвийн эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байгаа /2021 онд 3, 2022 онд 9, 2023 оны 19 хэрэг бүртгэгдсэн/, ялангуяа хулгайлах гэмт хэргийн улмаас хилийн чанадад өмчлөх эрх нь хууль бусаар бусдад шилжсэн соёлын өвийг эрэн сурвалжлах, олж тогтоох, эгүүлэн авах, хохирлыг барагдуулах чиглэлээр хууль ёсны өмчлөгчийн эрхийг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хамгаалахад учир дутагдалтай болж, ийм төрлийн гэмт хэргийг олон улсын гэрээний хүрээнд гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах замаар шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнтэй холбогдуулан "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенц нь соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг боловсронгуй болгох зорилгоор улс хооронд соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох болон буцаах тухай олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд соёлын өвийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэх механизм бүрдүүлэхэд чиглэдэг.

Энэхүү конвенц нь Монгол Улсын "Олон улсын гэрээний тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад "Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр

Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ"-г заавал соёрхон батална гэж заасан. Мөн соёлын эд зүйлийг буцаан авах талаар шүүхэд нэхэмжлэл, хүсэлт гаргах талаар уг конвенцид дурдсан байх тул Олон улсын гэрээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт зааснаар "соёрхон баталж, ...албан ёсоор нийтлэгдсэн Монгол Улсын олон улсын гэрээг шүүх ... хэрэглэх"-ээр заасны дагуу уг конвенцыг Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-ийн конвенцыг соёрхон баталснаар соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох болон буцаах чиглэлээр бусад улстай хамтран ажиллах болон олон улсын эрх зүйн хүрээнд соёлын өвийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх юм.

1995 оны "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн хүрээнд сөрөг үр дагавар гарахгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна. Хууль батлагдсанаар шинээр өөр хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох шаардлагагүй болно.